



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/37

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 28 дугаар зүйлийн 28.7.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаал "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.5.9, Засгийн газрын 2024 оны 63 дугаар тогтоол, сумын Онцгой комиссын 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улс орон даяар өвөлжилт хүндэрч, зудын эрсдэлт нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд өвөлжилт хүндэрсэн малчин, мал бүхий иргэдэд үнэ төлбөргүй өвс, тэжээл олгох шийдвэр гарсны дагуу өвс, тэжээлийг татан авч, малчдад тараах, цасанд боогдсон малчид руу зам гаргах ажлыг зохион байгуулсугай.

2. Сумын өвс, тэжээл татаж авах ажлын тээврийн хэрэгслийн шатахуунд 2024 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Гамшгаас хамгаалах арга хэмжээний зардал"-аас 3,000,000 (гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Гамшгаас хамгаалах арга хэмжээний зардал"-аас зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулахыг нягтлан бодогч (Л.Цэнд-Аюуш)-д зөвшөөрсүгэй.

4. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ч.СУГАРМАА

